



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 689

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй
үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.3, 9.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“ХААН банк” ХХК-ийн нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,912,198,000 (нэг тэрбум есөн зуун арван хоёр сая нэг зуун ерэн найман мянга) ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар (Б.Дөлгөөн)-т, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д тус тус зөвшөөрсүгэй.

2.“ХААН банк” ХХК-ийн нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,640,129,450 (нэг тэрбум зургаан зуун дөчин сая нэг зуун хорин есөн мянга дөрвөн зуун тавь) ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэ тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн, мөн нийт 80,848,750 (наян сая найман зуун дөчин найман мянга долоон зуун тавь) ширхэг хувьцааны өмчлөх эрхийг “ХААН банк” ХХК-аас гаргасан жагсаалтын дагуу тус компанийн хувьцаа эзэмшигчид болох нэр бүхий 4,136 ажилтны эзэмшилд тус тус баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 191,219,800 (нэг зуун ерэн нэгэн сая хоёр зуун арван есөн мянга найман зуу) ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийн үнийг 959 (есөн зуун тавин ес) төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “ХААН банк” ХХК (Р.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

4.Энэ тогтоолын 3-д заасан хувьцаанаас 162,536,830 (нэг зуун жаран хоёр сая таван зуун гучин зургаан мянга найман зуун гуч) ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийн үнийг 959 (есөн зуун тавин ес) төгрөгөөр “Бидисек ҮЦК” ХК-ийн тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчид худалдахыг зөвшөөрсүгэй.

5.Нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааг үнэт цаасны танилцуулгад тусгасан нөхцөлөөр анхдагч зах зээлд худалдахыг “Бидисек ҮЦК” ХК-д зөвшөөрч, олон нийтэд танилцуулах, сурталчлах болон хувьцааны захиалгыг эхлүүлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг үүрэг болгосугай.

6.Энэ тогтоолын 3-д заасан нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааг 100 (нэг зуу) хувь худалдсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохыг “ХААН банк” ХХК (Р.Мөнхтуяа)-д мэдэгдсүгэй.

7.Энэ тогтоолын 6-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Бидисек ҮЦК” ХК, “Таван богд капитал ҮЦК” ХХК (Г.Мөнх-Эрдэнэ)-д тус тус анхааруулсугай.

8.Энэ тогтоолын 3-д заасан хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны эрэлт нь нийлүүлэлтээс давсан тохиолдолд үнэт цаасны танилцуулгад тусгасан нөхцөлөөр хувьцааны хуваарилалтыг хийж, хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлэхийг “Бидисек ҮЦК” ХК, “Таван богд капитал ҮЦК” ХХК (Г.Мөнх-Эрдэнэ), “Монголын хөрөнгийн бирж” ХК (Х.Алтай), “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д тус тус үүрэг болгосугай.

9.Санхүүгийн зохицуулах хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д үүрэг болгосугай.

10.Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасан шаардлагыг биелүүлэхээс бусад тохиолдолд энэ тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (Ш.Лхагва)-д үүрэг болгосугай.

11.“ХААН банк” ХХК нь нээлттэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “ХААН банк” ХХК (Р.Мөнхтуяа)-д үүрэг болгосугай.

12.Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Бидисек ҮЦК” ХК, “Таван богд капитал ҮЦК” ХХК (Г.Мөнх-Эрдэнэ), “Өмгөөллийн Эм Жэй Эл атторнейс” ХХН (М.Мөнхжаргал), “Өмгөөллийн хаан лекс партнерс” ХХН (И.Учралбаяр), “Эрнст энд Янг монголия аудит” ХХК (Г.Алтансүх), “БДО аудит” ХХК (Д.Алтансүх)-д тус тус анхааруулсугай.

13.“ХААН банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй энгийн хувьцааг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанк (Б.Лхагвасүрэн)-д зөвлөсүгэй:

1/үнэт цаас гаргагч арилжааны банкны үйл ажиллагаанд Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд тогтмол хяналт тавьж ажиллах;

2/олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад заасны дагуу зарцуулж байгаа эсэхэд Санхүүгийн зохицуулах хороотой хамтран тогтмол хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллах;

3/үнэт цаас гаргагч арилжааны банк холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой аливаа зөрчил, дутагдал илэрсэн, банкны үйл ажиллагаанд аливаа эрсдэл үүссэн болон үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороонд тухай бүр хүргүүлж, хамтран ажиллах.

14.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2022 оны 12 дугаар сарын 09-ний
өдрийн 689 дүгээр тогтоолын хавсралт



№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Хувьцааны тоо ширхэг
1	“Эйч Эс Холдингс” ХК	40111-00-034411	783,882,300
2	“Таванбогд трейд” ХХК	2543303	435,653,100
3	Д.Хулан	ХП68082200	252,738,000
4	“Эйч Эс Интернэйшнл” (Ази) Лимитед	1201532	167,856,050
	Нийт дүн		1,640,129,450